

## **Иргэний нийгмийн байгууллагынханд баримт нягтлан шалгах (fact-checking) мэдлэг, ур чадвар олгох сургалт хийх хоёр хүртэл сургагч багш сонгон шалгаруулж хамтран ажиллах зар**

Хэвлэлийн Мэдээллийн Зөвлөл (ХМЗ) нь “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийн хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлж, мэргэжлийн баримт шалгагчидтай үр дүнтэй хамтран ажиллах мэдлэг, ур чадвараар хангах зорилготой сургалтыг зохион байгуулах хоёр хүртэл сургагч багш сонгон шалгаруулна.

### **Төслийн танилцуулга**

“Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг Европын Холбооны дэмжлэгтэйгээр Хэвлэл Мэдээллийн Зөвлөл, Дойче Велле Академи хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү сургалтаар ИНБ-уудыг баримт шалгах аргачлал, нягтлах ур чадварт сургах, өөрсдийн мэргэшсэн салбартаа баримт шалгах үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах чадамжтай болгохыг зорьж байна.

Мөн уг сургалт нь иргэний нийгмийн байгууллагууд болон баримт шалгах байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих бөгөөд олон нийтийн эрх ашгийг хөндсөн онцгой үйл явдлуудын үеэр хамтран ажиллах сайн туршлагыг хөгжүүлэхэд чиглэнэ. Түүнчлэн талуудын урт хугацааны хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх талаарх боломжийг эрэлхийлнэ.

### **Зорилго**

- Иргэний нийгмийн байгууллагуудын баримт шалгах, нягтлах талаарх ойлголт, чадамжийг нэмэгдүүлэх;
- Иргэний нийгмийн байгууллагууд болон мэргэжлийн баримт шалгагчдын хамтын ажиллагааг дэмжиж, олон нийтийн хэлэлцүүлгийн чанарыг сайжруулах, урт хугацааны хамтын ажиллагааны механизмыг судлах, хөгжүүлэх;
- Нийтийн эрх ашгийг хөндсөн сэдэв, асуудлаар баримтыг нягтлан олон нийтийн дуу хоолой болоход иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих.

### **Ажлын даалгаврын хамрах хүрээ**

Сургалт нь Улаанбаатар хотод танхимаар болон онлайнгаар зохион байгуулагдана. Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь:

- Нэг өдрийн сургалт, хоёр удаа (ижил агуулгатай):
  - Нэг удаагийн онлайн сургалт
  - Нэг удаагийн танхимын сургалт (Улаанбаатар хотод)
- Оролцогчид: Хот болон хөдөө орон нутгаас 20 хүртэл ТББ-ын ажилтан.
- Сургалтын агуулга:
  - Баримт шалгах арга зүй, нягтлах техник;
  - Мэргэжлийн баримт шалгагчидтай хамтран ажиллах сайн туршлага;
  - Сонгууль зэрэг нийтийг хамарсан үйл явдлын үеэрх улс төрийн мэдэгдлийг нягтлах, олон нийтэд мэдээлэх стратеги;
  - Иргэний нийгмийн болон баримт шалгах байгууллагуудын тогтвортой хамтын ажиллагааны загвар.

**Хугацаа:** 2025 оны 3-р сар – 2025 оны 6-р сар

### **Сургагч багшид тавигдах шаардлага, ур чадвар, туршлага:**

- Хэвлэл мэдээллийн боловсрол (MIL) / Баримт шалгах, нягтлах чиглэлээр туршлагатай байх – Баримт шалгах үйл ажиллагаанд ажиллаж байсан, энэ чиглэлээр төсөл хэрэгжүүлж байсан

- бол давуу тал болно;
- Хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх болон мэдээлэл олж авах эрхийн талаар мэдлэг, туршлагатай байх;
  - Сургалт зохион байгуулах туршлагатай байх – Интерактив сургалтын хөтөлбөр боловсруулах, оролцоонд тулгуурласан арга зүйгээр сургалт явуулах чадвартай байх. ИНБ-д сургалт хийж байсан туршлагатай бол давуу тал болно;
  - Харилцааны өндөр ур чадвартай байх – Төслийн баг, оролцогчид, оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллах чадвартай байх;
  - Үйл ажиллагааны баримт бичиг боловсруулах, тайлагнах чадвартай байх – Сургалт, арга хэмжээний тайлан, холбогдох баримт бичгийг боловсруулан тайлагнах чадвартай байх.

### Материал хүлээн авах

Сонирхсон оролцогчид дараах мэдээллийг нэгтгэсэн PDF файлаар илгээнэ:

- Сургалтын арга зүй, төлөвлөгөө, цагийн хуваарь бүхий ажлын төлөвлөгөө. Сургагч багш нар хоёр хүнтэй баг болж хамтран өргөдөл гаргах боломжтой;
- Хувь хүний намтар (CV) эсвэл байгууллагын танилцуулга (ижил төстэй төслүүд эсвэл үйл ажиллагааны туршлагыг харуулсан);
- Өргөдөлдөө өдрийн ажлын үнэлгээг тодорхой дурдах;
- Өмнө нь хэрэгжүүлсэн ижил төстэй сургалтын жишээ (боломжтой бол).

### Материалуудыг нэгтгэн нэг PDF файлаар монгол болон англи хэлээр 2025 оны 3-р сарын 21-ний дотор дараах хаягаар илгээнэ:

Хэнд: Хэвлэлийн Мэдээллийн Зөвлөл

Гарчиг: Хариуцлагатай ИНБ-уудын баримт шалгах хамтын ажиллагааны онлайн болон танхимын сургалтын сургагч багш

И-мэйл: [suvda@mediacouncil.mn](mailto:suvda@mediacouncil.mn)

---

**Төслийн зорилго:** Энэхүү төсөл нь иргэний нийгмийн байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэний нийгмийн хараат бус байдал, засаглалын сайн туршлагыг дэмжих, олон нийтийн мэдээлэлтэй оролцоог сайжруулах зорилготой. Монголын иргэний нийгмийн ашиг сонирхлыг мэргэжлийн түвшинд, ил тод, итгэлтэйгээр төлөөлөх чадавхыг бэхжүүлэх нь төслийн гол зорилт юм.

**Хэвлэл Мэдээллийн Зөвлөл (ХМЗ)** нь сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, амжилттай хамтын ажиллагааны үр дүнд 2015 оны эхээр байгуулсан хэвлэмэл, цахим, радио, телевизийн хараат бус өөрийн зохицуулалтын байгууллага юм.

ХМЗ нь олон нийтийн сонирхолд үйлчилснээр хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчдийг мэргэжлийн сэтгүүлзүйн хэм хэмжээг дагаж мөрдөхөд нь тусалдаг. Ингэхдээ бид Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчсөн хэмээн үзэж буй Монгол Улсын иргэний гомдлыг үнэ төлбөргүй бөгөөд шударгаар хэлэлцэж шийдвэр гаргадаг. Түүнчлэн бид хэвлэлийн эрх чөлөө, бие даасан ёс зүйтэй хэвлэл мэдээлэл, хариуцлагатай, ил тод иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулан бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах олон талт төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

**Дойче Велле Академи** нь Дойче Веллегийн олон улсын хэвлэл мэдээллийн хөгжил, сэтгүүл зүйн сургалт, мэдлэгийн солилцооны төв юм. Дойче Велле Академийн төслүүд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэлд саадгүй хүрэх хүний эрхийг бэхжүүлэхэд чиглэдэг. Дойче Велле Академи нь дэлхийн эргэн тойронд хүмүүсийг найдвартай баримт, бүтээлч хэлэлцүүлэгт тулгуурлан бие даан шийдвэр гаргах чадвартай болгоход дэмжлэг үзүүлдэг. Дойче Велле Академи нь ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны стратегийн түнш бөгөөд Холбооны Гадаад хэргийн яам, Европын Холбооноос санхүүжилт авч, дэлхийн 70 орчим хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудад идэвхтэй ажилладаг.